

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 01 сарын 12 -ны өдөр

Дугаар 05.18/12

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх
шинжилгээг төлбөртэй хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох,
орлогыг зарцуулах заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах зааврыг нэгдүгээр хавсралтаар, антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээний жишиг үнийг хоёрдугаар хавсралтаар, урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал /УТ-ПГУ/ шинжилгээний жишиг үнийг гуравдугаар хавсралтаар, эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжүүлэх урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал /УТ-ПГУ/ шинжилгээний жишиг үнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжүүлэх шинжилгээний төлбөрийг зохих журмын дагуу эрүүл мэндийн байгууллагуудад олгохыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэнд зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Я.Амаржаргал, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Мөнхдорж нарт даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд Ш.Анхмаа, Монгол Улсын шадар сайдын Ажлын албаны дарга бөгөөд Ахлах зөвлөх С.Янжинсүрэн нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД


Я.СОДБААТАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД


Т.МӨНХСАЙХАН

Монгол Улсын Шадар сайд,
Эрүүл мэндийн сайдын хамтарсан
2021 оны 07 сарын 12 -ны өдрийн 05.12/ тушаалын
нэгдүгээр хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫГ ИЛРҮҮЛЭХ
ШИНЖИЛГЭЭГ ХИЙХ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЖИШИГ ҮНЭ ТОГТООХ,
ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЗААВАР**

Нэг. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх заавар

1.1. Дараах тохиолдолд шинжилгээг төлбөртэй хийнэ.

1.1.1. Иргэний хүсэлтээр;

1.1.2. Аж ахуй нэгж байгууллага нь албан хаагчид болон ажилтнуудаа шинжилгээнд хамруулах хүсэлт гаргасан бол;

1.1.3. Гэрийн тусгаарлалт болон тусгаарлах байрнаас зөвшөөрөлгүй гарч эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулсан нь тогтоогдсон бол;

1.1.4. Гадаадын харъяат иргэн бол;

1.2. Дараах тохиолдолд шинжилгээний төлбөр авахыг хориглоно.

1.2.1. 16 хүртэлх насны хүүхэд;

1.2.2. Жирэмсэн эмэгтэй;

1.2.3. Эх амаржсанаас хойш 56 хүртэлх хоногтой;

1.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

1.2.5. 60 болон түүнээс дээш настай иргэн;

1.2.6. Хөдөлмөрийн чадвар алдалттай иргэн;

1.2.7. Хорт хавдартай иргэн;

1.2.8. Тархвар зүйн заалтаар шинжилгээнд хамрагдаж байгаа иргэн /сэжигтэй тохиолдол, ойрын хавьтал, хоёрдогч хавьтал/;

1.2.9. Эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагатай иргэн;

1.2.10. Зорилтот бүлэг /цагдаа, мэргэжлийн хяналт, эрүүл мэнд, онцгой байдлын албан хаагч/;

1.2.11. Албан үүргээ гүйцэтгэхэд тавигдах шаардлагаар шинжилгээнд хамрагдаж байгаа /томилолтоор явах, тусгай хамгаалалтын бүсэд нэвтрэх гэх мэт/ төрийн албан хаагч.

Хоёр. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээний жишиг үнэ

2.1 Жишиг үнэ тогтоохдоо оношлуур, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын бодит өртөг, сорьц цуглуулах, тээвэрлэх тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг шингээж тооцоолно.

2.2 Шинжилгээний жишиг үнэ:

2.2.1 Антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээний жишиг үнэ – тус бүр 25,000 төгрөг /хоёрдугаар хавсралт/

2.2.2 Урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал /УТ-ПГУ/ шинжилгээний жишиг үнэ – 82,370 төгрөг /Үүнд: сорьц авахад 30,565 төгрөг, сорьц шинжлэхэд 51,805 төгрөг/ /гуравдугаар хавсралт/

2.2.3 Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжүүлэх урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал /УТ-ПГУ/ шинжилгээний жишиг үнэ – 82,370 төгрөг /Үүнд: сорьц авахад 30,565 төгрөг, сорьц шинжлэхэд 51,805 төгрөг/ /дөрөвдүгээр хавсралт/

2.3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банкинд хадгалуулах журам”-ын 4.2.2 дахь заалтыг үндэслэн энэхүү зааврын 1.2-т заасан тохиолдлын шинжилгээг эрсдэлийн сангаас санхүүжүүлнэ.

2.3.1 Тус эрсдэлийн сангаас санхүүжилт авах эрүүл мэндийн байгууллага нь багц шинжилгээний 82,370 төгрөгөөс сорьц цуглуулсан эрүүл мэндийн байгууллага руу 30,565 төгрөгийг нэхэмжлэл болон санхүүгийн анхан шатны маягтыг үндэслэн санхүүжүүлж үлдэх 51,805 төгрөгийг тус байгууллага өөрийн үйл ажиллагаанд зарцуулна.

2.3.2 Эрсдэлийн сангаас бүх нийтийг хамруулсан шинжилгээг санхүүжүүлэхийг хориглоно.

Гурав. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээ хийсэн төлбөрийг байгууллагын төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж дараах байдлаар зарцуулна:

3.1. Молекулбиологийн лабораторийн оношлуур, урвалж, дагалдах хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодис худалдан авах;

3.2. Тусгаарлан ажиглах байранд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд зарцуулсан эм, эмнэлгийн хэрэгсэл;

3.3. Дайчлагдан ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны цалин, илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, урамшуулал;

3.4. Сорьц тээвэрлэх, тандалт хийх, гэрийн тусгаарлалтад байгаа иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгслийн шатахууны зардал;

3.5. Иргэдэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны зардал;

3.6. Шинжилгээний цахим бүртгэл, анхан шатны маягтын хэвлэлт;

Дөрөв. Төлбөртэй шинжилгээний орлого, зарцуулалтын тайланг тухай бүр нь байгууллагын шилэн дансанд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Монгол Улсын Шадар сайд,
Эрүүл мэндийн сайдын хамтарсан
2021 оны 01 сарын 12-ны өдрийн 05/19/ тушаалын
хоёрдугаар хавсралт

АНТИГЕН ИЛРҮҮЛЭХ ЭСВЭЛ IGM, IGG ЭСРЭГ БИЕ
ИЛРҮҮЛЭХ ТҮРГЭВЧИЛСЭН ТЕСТИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
ЖИШИГ ҮНЭ

№	Бүтээгдэхүүний нэр	Нэг хүнд ногдох өртөг /төгрөг/
1	AG RDT эсвэл IgM, IgG оношлуур	14,620
2	Комбинзон	2,800
3	Малгай	31
4	Маск N95	2,000
5	Нүүрний хаалт	284
6	Бээлий	550
7	Аюултай хог хаягдлыг устгах, ариутгах зардал	1,500
8	Цалин НДШ	3,216
НИЙТ ДҮН		25,000

Монгол Улсын Шадар сайд,
 Эрүүл мэндийн сайдын хамтарсан
 2021 оны 01 сарын 12-ны өдрийн 05/12 тушаалын
 гуравдугаар хавсралт

УРВУУ ТРАНСКРИПТАЗАТ-ПОЛИМЕРАЗИЙН
 ГИНЖИН УРВАЛ /УТ-ПГУ/ ШИНЖИЛГЭЭНИЙ ЖИШИГ ҮНЭ

№	Бүтээгдэхүүний нэр	Нэг хүнд ногдох өртөг/төгрөг/
Сорьц авах үе:		
1	Сорьц авах бамбар болон тубе	2,100
2	Комбинзон	5,600
3	Малгай	31
4	Маск N95	5,000
5	Нүүрний хаалт	284
6	Бээлий	550
7	Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах зардал	1,500
8	Цалин НДШ	15,000
9	Бусад зардал	500
Сорьц авах нийт дүн		30,565
Шинжилгээ хийх үе:		
9	PCR болон PHX ялгах урвалж, оношлуур	25,605
10	Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах зардал	1,500
11	Комбинзон	2,800
12	Малгай	31
13	Маск N95	2,000
14	Нүүрний хаалт	284
15	Бээлий	69
16	Бусад зардал	500
17	Цалин НДШ	19,017
Шинжилгээ хийх нийт дүн		51,805
НИЙТ ДҮН		82,370

Монгол Улсын Шадар сайд,
 Эрүүл мэндийн сайдын хамтарсан
 2021 оны 01 сарын 10 -ны өдрийн 0512/10 тушаалын
 дөрөвдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЭРСДЭЛИЙН САНГААС
 САНХҮҮЖҮҮЛЭХ УРВУУ ТРАНСКРИПТАЗАТ-ПОЛИМЕРАЗИЙН ГИНЖИН УРВАЛ
 /УТ-ПГУ/ ШИНЖИЛГЭЭНИЙ ЖИШИГ ҮНЭ**

№	Бүтээгдэхүүний нэр	Нэгж өртөг /төгрөг/	Нэг хүнд ногдох өртөг /төгрөг/	Багцад ногдох өртөг /төгрөг/
Сорьц авах үед				
1	Сорьц авах бамбар болон тубе	2,100	2,100	8,400
2	Комбинзон	28,000	5,600	5,600
3	Малгай	307	31	31
4	Маск N95	20,000	5,000	5,000
5	Нүүрний хаалт	2,836	284	284
6	Бээлий	550	550	2,200
7	Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах зардал	1,500	1,500	1,500
8	Цалин НДШ	5000	15,000	7,050
9	Бусад зардал	500	500	500
Сорьц авах нийт дүн				30,565
Шинжилгээ хийх үед				
9	PCR болон PHX ялгах урвалж, оношлуур	25,605	6,401	25,604
10	Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах зардал	1,500	1,500	1,500
11	Комбинзон	28,000	2,800	2,800
12	Малгай	307	31	31
13	Маск N95	20,000	2,000	2,000
14	Нүүрний хаалт	2,836	284	284
15	Бээлий	550	69	69
16	Бусад зардал	500	500	500
17	Цалин НДШ	19018	4,755	19,018
Шинжилгээ хийх нийт дүн				51,805
НИЙТ ДҮН				82,370